



BULIGAR

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН
МАТЕРИАЛ**

2021 ОН

ХУРЛЫН МАТЕРИАЛЫН АГУУЛГА

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг
2. Хувьцаа эзэмшигчдийг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол
3. Хурлаар хэлэлцэх асуудал
4. 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлт
5. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн товч танилцуулга
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төсөл
7. Саналын хуудасны загвар

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

-
1. Хурлын ирцийг гаргаж хурлын даргад мэдэгдэх 14:00-14:03
/Тооллогын комиссын дарга Б.Баянжаргал/
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулах 14:03-14:05
/Хурлын дарга Б.Анхболд/
3. Тооллогын комиссыг томилсон тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах 14:06
/Хурлын зохион байгуулах комиссын гишүүн Ц.Мөнхлхагва/
4. Хэлэлцэх асуудлын дагуу дараах илтгэлүүдийг тавина:
- Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах 14:06-14:16
Гүйцэтгэх захирал Б.Анхболд/
 - ТУЗ-өөс компанийн 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг танилцуулах 14:16-14:30
 - 2020 оны санхүүгийн үр дүнгээс ноогдол ашиг тараах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
 - ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг товч танилцуулах
/ТУЗ-ийн дарга А.Энхмэнд/

Үргэлжлэл

- | | |
|---|-------------|
| 5. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт | 14:30-14:35 |
| 6. Санал хураалт | 14:35-14:38 |
| 7. Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах | 14:35-14:38 |
| 8. Хурлаас гарах тогтоолын төсөлд санал хураалтын дүнг тусган танилцуулж, тогтоолыг батлуулах | 14:38-14:40 |
| <i>/Хурлын дарга Б.Анхболд/</i> | |
| 9. Хурлыг хаах | 14:38-14:40 |

Хурлын үргэлжлэх хугацаа: 40 минут

Жич: Шаардлагатай бол хурлын хугацааг сунгах болно.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Тооллогын комисс томилох тухай ТУЗ-ийн тогтоол



“МОН-ИТ БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.4 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 65-р зүйлийн 65.3, 65.4 дэхь заалт, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.18 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, компанийн 2021 оны 3 дугаар сарын 10-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. “Мон-Ит Булигаар” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 14:00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, “Мон-Ит Булигаар” ХК-ийн байранд хуралдуулсугай.

Хоёр. “Мон-Ит Булигаар” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.

2.1. “Мон-Ит Булигаар” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

2.2. “Мон-Ит Булигаар” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох;

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд тус тус хүргүүлсүгэй.

Дөрөв. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр тогтоосугай.

Тав. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай зарыг 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Монголын хөрөнгийн биржийн сахим хуудсаар дамжуулан олон нийтэд зарлан, зарыг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан

мэдээлсүгэй. Энэхүү хурлын зарыг анх зар хүргэсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2021 оны 03 дугаар сарын 30-ний өдөр дахин зарлан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.

Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой баримт бичгийг 2021 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн дотор үнэт цаасны брокер дилерийн компаниудад хүргүүлсүгэй.

Долоо. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Б.Анхболдыг мөн хурал зохион байгуулах комиссын даргаар А.Энхмэнд, гишүүдэд Ц.Мөнхлхагва, Н.Тэмүүжин нарыг сонгосугай.

Найм. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай.

Хурлын тооллогын комиссын дарга – Б.Баянжаргал

Хурлын тооллогын комиссын гишүүд – М.Төрхүү, Д.Ариунбилэг

Ес. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудасны загварыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Арав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нийтэд хүргэх зарын загварыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

Арван нэг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал, баримт бичгийг гуравдугаар хавсралтаар баталсугай. Энэхүү хурлын материалтай ажлын өдрийн 09:00-18:00 цагийн хооронд хувьцаа эзэмшигчид танилцах боломжийг бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал Б.Анхболд-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



А.ЭНХМЭНД

КОМПАНИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ ТАНИЛЦУУЛАХ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.АНХБОЛД

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ, та бүхний амар амгаланг айлтгаж, энэ эрсдэлт цаг үед эрхэм дээд эрүүл мэнд, энх тунхыг хүсэн ерөөе.

○ **Үйл ажиллагааны талаар:**

Компанийн борлуулалтын орлого болон бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, туршилт судалгаа хийх, өдөр тутмын ашиглалтын зардлыг хэмнэхэд анхааран ажилласан. Сүүлийн жилүүдэд эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл зогссон байсанг хэвийн ажиллагаанд оруулж 2020 онд гутал, хувцас, цүнх, жижиг эдлэлийн зориулалттай арьсыг бүх төрлөөр үйлдвэрлэж, дотоодын зах зээлд борлуулж эхэлсэн.

Дотоодын зах зээлд энгийн болон ус нэвтрэхгүй хөдөлмөр хамгааллын гутлын зориулалттай болон гоёлын гутлын арьсыг түлхүү бэлтгэн нийлүүлж байна.

Компани нь туршилт судалгаа хийсний үндсэн дээр хувцасны зориулалттай үхрийн арьс, улны шир /цагаан ултай гутал/, бүсний шир зэрэг бүтээгдэхүүнийг шинээр үйлдвэрт нэвтрүүлэн үйлдвэрлэж байна. Одоогийн байдлаар манай компани нь бүх төрлийн бэлэн бүтээгдэхүүний зориулалттай арьсыг боловсруулах техникийн хүчин чадалтай болсон.





Манай үйлдвэрийн хувьд өнөөдрийн байдлаар Турк, БНХАУ зэрэг улс руу хонь болон ямааны арьсыг wet-blue түвшинд боловсруулан экспортолж байна.

Цаашид илүү нэмүү өртөг шингээж Испани, Турк, Энэтхэг, БНХАУ зэрэг орнууд руу үхрийн арьсыг крастын түвшинд экспорт хийхийг зорин ажиллаж байна.

○ Санхүүгийн талаар:

2020 онд “Мон-Ит Булигаар” ХК нь 2,965,138,608.05 төгрөгийн борлуулалтын орлого олж, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 3,429,779,173.55 төгрөг, үндсэн үйл ажиллагаанд 1,016,493,165.90 төгрөгийн зардал гаргаж 1,481,133,731.40 төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Компани нь татвараа үнэн зөв тодорхойлж, төлөх тайлагнах үүргээ нэр төртэй биелүүлж нийгмийн хариуцлагаа үлгэр жишээ сахин, эх орныхоо бүтээн байгуулалт хөгжилд бодитой хувь нэмэр оруулж ирлээ. “Мон-Ит Булигаар” ХК нь 2020 онд улсын татварт 26,268,944.00 төгрөгийн татвар төлжээ.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



- Мон-Ит Булигаар ХК нь хоёр дахь жилдээ Leather Partners-2020 арга хэмжээг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд арьс ширээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 80 гаруй аж ахуй нэгж болон хувь хүмүүс оролцсон.
- Тус арга хэмжээ компанийн үйлдвэрийн байранд зохион байгуулагдсан бөгөөд арга хэмжээнд оролцогч нарт үйлдвэрийн үйл ажиллагаа болон шинээр үйлдвэрлэж байгаа боловсруулсан арьсаа танилцуулснаараа илүү онцлогтой болсон.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



- “Шинэ эдийн засаг - Увс хамтын ажиллагааны санаачилга” бизнес форум-д оролцов.

Компани нь 2020 оны 09 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд Увс аймгийн Улаангом суманд зохион байгуулагдсан уг бизнес форумд амжилттай оролцож, өөрсдийн бүтээгдэхүүнээ сурталчлан танилцуулах, худалдан борлуулах өдөрлөг хийв.

- "Ноос ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүн-2020" үзэсгэлэнд оролцов.



Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг энэхүү үзэсгэлэн 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Мишээл экспод болсон бөгөөд уг үзэсгэлэнг үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ноос, ноолуур, арьс ширний салбарын экспортын бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулах, экспортыг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийг нэг дороос худалдан авалт хийх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ХХААХҮЯам, Монголын Ноос Ноолуурын Холбоо, Монголын Арьс Ширний Үйлдвэрлэлийн Холбоо, Мишээл Экспо хамтран зохион байгуулсан юм.

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА А.ЭНХМЭНД

“Мон-Ит Булигаар” хувьцаат компанийн удирдлагын баг болон нийт хамт олны 2020 оны төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн үйл ажиллагааны үр дүн, мөн санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс танилцуулж буйдаа таатай байна. Тайлант хугацаанд “Мон-Ит Булигаар” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр А.Энхмэнд, Б.Анхболд, Б.Баянжаргал, Д.Гансүх, М.Бат-Очир, ТУЗ-ийн хараат бус гишүүдээр Н.Мягмардорж, Ц.Баярсайхан, н.Аюуш, Н.Батхуяг нар, компанийн Гүйцэтгэх захирлаар Б.Анхболд, Ерөнхий нягтлан бодогчоор М.Төрхүү нар ажиллалаа. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл компанийн хэтийн төлөв, зорилтыг тодорхойлон хууль дүрэм журамд заасан эрх үүргийн хүрээнд компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, түүний дэргэдэх хороод нь хорооны эрх мэдлийн хүрээнд ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж Гүйцэтгэх удирдлага нь өдөр тутмын удирдлагаар ханган ажиллаж ирлээ.

Үйл ажиллагааны талаар: Компанийн борлуулалтын орлого, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, туршилт судалгаа хийх, өдөр тутмын ашиглалтын зардал, барилгын урсгал засварын зардлуудыг багасган, хэмнэн ажиллахад анхааран ажиллаж байгааг Гүйцэтгэх удирдлага ТУЗ-ийн ээлжит хурлуудад байнга танилцуулж байсан.

Компани нь сүүлийн жилүүдэд эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь зогссон байсанг сэргээж, 2020 онд гутал, хувцас, цүнх, жижиг эдлэлийн зориулалттай арьсыг бүх төрлөөр үйлдвэрлэж, дотоодын зах зээлд борлуулж эхэлсэн нь компанийн хувьд томоохон амжилт юм. Үүнээс гадна туршилт судалгаа хийсний үндсэн дээр хувцасны зориулалттай үхрийн арьс, улны шир /цагаан ултай гутал/, бүсний шир зэрэг бүтээгдэхүүнийг шинээр үйлдвэрлэж байгаа нь том амжилттай байна. Одоогийн байдлаар манай компани нь бүх төрлийн бэлэн бүтээгдэхүүнд зориулсан арьсыг боловсруулах техникийн чадамжтай болсон. Дотоодын зах зээлд энгийн болон ус нэвтрэхгүй хөдөлмөр хамгааллын гутлын зориулалттай болон гоёлын гутлын арьсыг түлхүү бэлтгэн нийлүүлж байна. Манай үйлдвэрийн хувьд өнөөдрийн байдлаар Турк, БНХАУ зэрэг улс руу хонь болон ямааны арьсыг wet-blue түвшинд боловсруулан экспортолж байна. Цаашид илүү нэмүү өртөг шингээж Испани, Турк, Энэтхэг, БНХАУ зэрэг орнууд руу үхрийн арьсыг крастын түвшинд экспорт хийхийг зорин ажиллаж байна.

Барилга болон тоног төхөөрөмжийн засвар, ашиглалт үйлчилгээний талаар:

Тайлант хугацаанд үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, барилгын шинэчлэлт, үйл ажиллагаагаа сайжруулахад дотоод нөөц бололцоондоо тулгуурлан томоохон ажлууд хийсэн. Үүнээс дурьдвал, компанийн тоног төхөөрөмжийн үндсэн зориулалт нь бодийн арьс боловсруулах байсанг тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, махлах машин /2 ширхэг/, индүү буюу нойтон сунгах машин /1 ширхэг/ зэрэг тоног төхөөрөмжийг шинээр худалдан авсан. Ингэснээр богийн арьсыг гүйцэд боловсруулах тоног төхөөрөмжийн шаардлага хангаж, бүх төрлийн богийн арьс боловсруулах хүчин чадалтай болж, улмаар богийн арьс их хэмжээгээр үйлдвэрлэл эхэлсэн. Түүнчлэн удаан хугацаанд ажиллах боломжгүй гэмтэлтэй байсан шүрших агрегат машин, молисса буюу раман хатаалгын машин зэрэг тоног төхөөрөмжид их засвар хийж ажиллагаанд оруулсан.

Үүнээс гадна барилга байгууламжийн засварын дараах ажлуудыг хийсэн.

5,800 гаруй м2 гадна фасадын их засвар болон 750 ширхэг цонхонд усны хаялаг хийж барилга байгууламжийн гадна фасадыг иж бүрэн засварласан.

Барилгын нэг хэсэг болох химийн боловсруулах цехийн дээврийг бүрэн хуулж, шинээр цутгалт хийж ус чийгийг тусгаарлах PVC мембран дээвэр хийсэн.

Барилгын 6-р давхрын 2200м² талбайг орчин үеийн стандартыг хангасан оффис болон үйлдвэрлэлийн зориулалтаар бүрэн засварлаж, ашиглалтад оруулсан.

Барилгын 1-р давхрын гол хаалганы үүдний хэсгийн 83м² талбайг иж бүрэн засварласан.

Барилгын баруун жигүүрийн 1-р давхрын хонгилын 240м² талбайг засварласан, түүнчлэн ажилтнуудын амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх өрөө болон хувцас солих өрөө болон усанд орох, угаалга хийх өрөөнүүдийг иж бүрэн засаж тохижуулан ашиглалтад оруулав.

Дээрх засварт зарцуулсан хөрөнгө оруулалт бол зөвхөн барилга байгууламжийн хувьд үйлдвэрлэл хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх, уур ус, дулааны зардлаа хэмнэх, мөн түүнчлэн ажилтнуудыг дулаахан, ая тухтай орчинд ажиллах боломжтой болгосон.

Санхүүгийн үйл ажиллагааны талаар:

Тус компани өнгөрсөн онд нийтдээ 2,965,138,608.05 төгрөгийн орлого олсон. Тайлант хугацаанд өнгөрсөн оныхоос 2,355,403,037.51 төгрөгөөр борлуулалт нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд 1,016,493,165.90 төгрөгийн үйл ажиллагааны зардал гарсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 405,130,421.60 төгрөгөөр өссөн бөгөөд үүнээс үйл ажиллагааны зардлын 378,860,884.19 төгрөгийг ашиглалтад, 54,177,051.05 төгрөгийг урсгал засвар хийхэд, 155,811,521.00 төгрөгийг зээлийн хүүгийн зардалд зарцуулсан байна.

Өнгөрсөн оны жилийн эцсийн байдлаар нийт хөрөнгийн дүн 17,611,443,340.00 төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 34,8 хувь буюу 6,134,092,093.00 төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 65,2 хувь буюу 11,477,351,247.00 төгрөгийг эзэлж байна.

Эргэлтийн хөрөнгийн 27 хувь буюу 1,655,205,909.36 төгрөгийг мөнгө, авлага зэрэг түргэн хөрвөх хөрөнгө, 69,8 хувь буюу 4,282,101,666.00 төгрөгийг бараа материал, 3,2 хувь буюу 196,784,517.00 төгрөгийг урьдчилж төлөгдсөн зардал эзэлж байна. Эргэлтийн бус хөрөнгийн дийлэнх хувь болох 86,9 хувь буюу 9,980,498,799.00 төгрөгийг үндсэн хөрөнгө болох барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, 13,1 хувь буюу 1,496,852,448.00 төгрөгийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Өр төлбөр ба Эзэмшигчдийн өмчийн хувьд бусдад төлөх өр төлбөрийн хэмжээ 11,119,109,720.00 төгрөг, эзэмшигчдийн өмчийн дүн 6,492,333,620.00 төгрөг байна. Нийт өр төлбөрийн 67,4 хувь буюу 7,499,519,212.00 төгрөгийг богино хугацаат өр төлбөр, 32,6 хувь буюу 3,619,590,508.00 төгрөгийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна. Эзэмшигчдийн өмч оны эхэнд 7,925,888,297.00 төгрөг байсан бол оны эцэст 6,492,333,620.00 төгрөг болж нь хуримтлагдсан алдагдал өссөнтэй холбоотой байна.

Иймд “Мон-Ит Булигаар” хувьцаат компанийн гүйцэтгэх удирдлагын баг 2020 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн ашиглаж, компанийн үр ашгийг нэмэгдүүлэх, хэтийн зорилгодоо хүрэх, компанийн хөгжлийг урагшуулах үр дүнтэй алхмуудыг хийж, Монгол Улсын хуулийн хүрээнд зах зээлийн өнөөгийн байдалд зохицсон үйл ажиллагааг явуулж ажилласан гэж Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс дүгнэж байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН ТАЙЛАН			
№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		<i>/Мянган төгрөг/</i>	
1	ХӨРӨНГӨ	0	0
1.1	Эргэлтийн хөрөнгө	0	0
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	28178.5	25878.3
1.1.2	Дансны авлага	1879387.6	1326474.5
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	0	302055.8
1.1.4	Бусад авлага	83189.4	797.3
1.2	Бусад санхүүгийн хөрөнгө	0	0
1.1.5	Бараа материал	2504161.9	4282101.7
1.1.6	Эргэлтийн хөрөнгийн дүн	4494917.4	6134092.1
1.1.7	Эргэлтийн бус хөрөнгө	0	0
1.1.8	Үндсэн хөрөнгө	9982440.9	9980498.8
1.3	Биет бус хөрөнгө	1655802.5	1496852.4
1.1.9	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11638243.4	11477351.2
1.1.10	Нийт хөрөнгийн дүн	16133160.8	17611443.3
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0	0
2.1	ӨР ТӨЛБӨР	0	0
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	0
2.1.1.1	Дансны өглөг	1770304.9	4168486.5
2.1.1.2	Татварын өр	86555	415680
2.1.1.3	НДШ - ийн өглөг	75359	142395.8
2.1.1.4	Богино хугацаат зээл	2498202.6	2187556.8
2.1.1.5	Хүүний өглөг	31603.7	535400
2.1.1.6	Ногдол ашгийн өглөг	0	0
2.1.1.7	Урьдчилж орсон орлого	124584.2	50000
2.1.1.8	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4586609.4	7499519.1
2.1.1.9	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	0
2.1.1.10	Урт хугацаат зээл	3620663.1	3619590.5
2.1.1.11	Урт хугацаат өр төлбөрийн дүн	3620663.1	3619590.5
2.1.1.12	Өр төлбөрийн нийт дүн	8207272.5	11119109.6
3	ЭЗДИЙН ӨМЧ	0	0
3.1	Өмч	40021.2	40021.2
3.1.1	-хувьцаат	40021.2	40021.2
3.1.2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4939092.3	4939092.3
3.1.3	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0	0
3.1.4	Эздийн өмчийн бусад хэсэг	266001	266001
3.1.5	Хуримтлагдсан ашиг	2680773.8	1247219.2
3.1.6	Эздийн өмчийн дүн	7925888.3	6492333.7
3.1.7	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	16133160.8	17611443.3

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН			
№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		<i>/Мянган төгрөг/</i>	
1	Борлуулалтын орлого (цэвэр)	609,735.6	2,965,138.6
2	Борлуулалтын өртөг	486,901.4	3,429,779.1
3	Нийт ашиг (алдагдал)	122,834.2	-464,640.5
4	Түрээсийн орлого	19,824.0	0.0
5	Хүүний орлого	15.0	0.0
6	Ногдол ашгийн орлого	0.0	0.0
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.0	0.0
8	Бусад орлого	45,047.9	47,578.7
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.0	0.0
10	Ерөнхий ба удирдлагын зардал	611,362.7	1,016,493.2
11	Санхүүгийн зардал	0.0	0.0
12	Бусад зардал	118,683.6	0.0
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-126,234.5	0.4
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.0	0.0
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.0	0.0
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.0	0.0
17	Бусад ашиг (алдагдал)	0.0	0.0
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-668,559.7	-1,433,554.6
19	Орлогын татварын зардал	1.5	0.0
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	-668,561.2	-1,433,554.6
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараахь ашиг (алдагдал)	0.0	0.0
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-668,561.2	-1,433,554.6
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.0	0.0
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.0	0.0
23.3	Бусад олз (гарз)	0.0	0.0
24	Орлогын нийт дүн	-668,561.2	-1,433,554.6
24.1	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.0	0.0

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН									
№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	/Мянган төгрөг/
									Нийт дүн
1	20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	40,021.2	0.0	0.0	4,939,092.3	1.0	266,000.0	3,329,216.5	8,574,331.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.0	0.0	0.0	0.0	1.0	0.0	1.0
3	Залруулсан үлдэгдэл	40,021.2	0.0	0.0	4,939,092.3	0.0	266,001.0	3,329,216.5	8,574,331.0
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	-668,561.2	-668,561.2
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
6	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	20,118.5	20,118.5
7	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
9	20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	40,021.2	0.0	0.0	4,939,092.3	0.0	266,001.0	2,680,773.8	7,925,888.3
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.0	0.0	0.0	-1.0	0.0	0.0	-1.0
11	Залруулсан үлдэгдэл	40,021.2	0.0	0.0	4,939,092.3	0.0	266,001.0	2,680,773.8	7,925,888.3
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	-1,433,554.6	-1,433,554.6
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
15	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
17	20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	40,021.2	0.0	0.0	4,939,092.3	0.0	266,001.0	1,247,219.2	6,492,333.7

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН			
№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
1.1	Мөнгөн орлогын дүн	650,063.6	2,700,349.6
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	552,963.6	2,407,132.0
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	4,418.0	0.0
1.1.4	Бүцаан авсан албан татвар	1,385.6	0.0
1.1.6	Бусад мөнгөн орлого	91,296.4	293,217.6
1.2	Мөнгөн зарлагын дүн	6,079,521.7	2,056,428.5
1.2.1	Ажиллагчдад төлсөн	344,409.5	616,412.9
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	29,411.0	0.0
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	5,173,726.3	718,991.6
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	313,914.6	378,860.9
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	31,878.9	49,114.1
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.0	155,811.5
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	6,929.0	26,268.9
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.0	200.0
1.2.9	Бусад мөнгөн зарлага	179,252.4	110,768.6
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-5,429,458.1	643,921.1
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
2.1	Мөнгөн орлогын дүн	15.0	0.0
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	15.0	0.0
2.2	Мөнгөн зарлагын дүн	6,268.0	0.0
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,268.0	0.0
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-6,253.0	0.0
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
3.1	Мөнгөн орлогын дүн	5,541,095.3	12,610.2
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	5,541,095.3	18,160.2
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.0	-5,550.0
3.2	Мөнгөн зарлагын дүн	77,254.0	658,831.9
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	77,254.0	658,831.9
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,463,841.3	-646,221.7
4	Валютын ханшийн зөрүү	-1,522.4	0.4
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	26,607.8	-2,300.2
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	1,570.7	28,178.5
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	28,178.5	25,878.3

АУДИТЫН ДҮГНЭЛТ



АКПАР АУДИТ ХХК

“МОН-ИТ БУЛИГААР” ХК

2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЫГ ДУУСГАВАР БОЛГОСОН ТУХАЙ ТАЙЛАН

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

“Акпар-Аудит” компанийн:

Ерөнхий захирал

Х.Баянбай

Аудитор

М.Хосбаяр

Чанарын хяналтын менежер

Д.Хишигсүрэн

Аудитын тайлантай холбоотой
асуудлаар нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал 91919758
дугаарын утсаар харицана уу

ХАЯГ:

Баянзүрх дүүрэг, 3-р хороо,

Токиогийн гудамж 45а,

Оршил төвийн 7 давхар 701 тоот

Утас: 91919758

E-mail: akpar.audit@gmail.com

bayanbai_havdan@yahoo.com

АГУУЛГА:

хуудас

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын дүгнэлт	2
Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	3
Байгууллагын талаархи мэдээлэл	3
Материаллаг байдлын түвшин	3
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	3
Тасралтгүй үйл ажиллагааны талаарх мэдээлэл	3
Балансын дараах үйл явдал	3
Аудит хийгдсэн Санхүүгийн байдлын тайлан	4
Аудит хийгдсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	5
Аудит хийгдсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	5
Аудит хийгдсэн Мөнгөн гүйлгээний тайлан	6
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	
Мөнгөн хөрөнгө	7
Дансны авлага	7
Татварын авлага	7
Бусад авлага	8
Бараа материал	8
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	8
Үндсэн хөрөнгө	8
Үндсэн хөрөнгийн элэгдэл	9
Биет бус хөрөнгө	9
Биет бус хөрөнгийн хөрөгдөл	9
Богино хугацаат өглөг	9
Урт хугацаат зээл	10
Үйл ажиллагааны орлого	10
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	10
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	11
Удирдлагын зардал	11
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	11
Аудиторос өгсөн зөвлөмж	12



АКПАР АУДИТ ХХК
AKPAR AUDIT LLC

“МОН-ИТ БУЛИГААР” КОМПАНИЙН
УДИРДЛАГАД

Хараат бус аудиторын
тайлан

Бид Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн холбогдох заалтуудыг үндэслэн “Мон-Ит Булигаар” ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан буюу тайлангийн тодруулгуудаас бүрдсэн жилийн эцсийн Санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар “Мон-Ит Булигаар” ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. АОУС-д заасан аудиторын хүлээх үүрэг, хариуцлагыг “Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага” гэсэн хэсэгт тусгаж харуулав. Аудитын ажилд хамааралтай хараат бус байдлын болон ёс зүйн шаардлагуудыг бүрэн биелүүлж ажилласан. Бидний олж авсан баримт нотолгоонууд дээрх дүгнэлтийг гаргахад хангалттай, тохиромжтой гэж үзэж байна.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлангаа СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан заавар журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, хуульд нийцүүлэн боловсруулан, тогтмол мөрдөж ажиллах нь тухайн байгууллагын удирдлагын үүрэг болно.

Мөн түүнчлэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хөрөнгийг янз бүрийн зальт ажиллагаанд өртүүлэхгүй байхаар дотоод хяналтын системийг бий болгох, байгууллагын үйл ажиллагааны болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурь, зарчмыг хангаж ажиллах нь байгууллагын удирдлагын хариуцлага юм.

Улаанбаатар хот

2021 оны 3-р сар

Ажлын байр: Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Токиогийн гудамж 45а, Оршил төв 701 тоот
Утас: 976-91919758, 976-96969758

И-мэйл: akpar.audit@gmail.com

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага

Аудиторын гол зорилго нь үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангийн улмаас материаллаг буруу илэрхийллээс ангид эсэхэд дүгнэлт өгөхөд оршино. Тодорхой дүгнэлтэд хүрэхийн тулд АОУС-д нийцүүлэн боловруулсан горимын дагуу шалгалт хийж, хангалттай, тохиромжтой баримт нотолгоо цуглуулах нь аудиторын үүрэг юм.

Аудитын горимуудыг батлагдсан төлөвлөгөөний дагуу аудитор өөрийн шийдлээр сонгох ба ирүүлсэн алдаа, зөрчил нь материаллаг буюу байгууллагын удирдлага болон хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх эсэхэд дүн шинжилгээ хийж, түүнд тохирсон дүгнэлт өгнө.

Аудитын шалгалтаар байнга алдаа зөрчил илрэх ёстой гэсэн ойлголт байж болохгүй бөгөөд бидний илрүүлсэн алдаа, зөрчил материаллаг бус бол түүнийг арилгуулах талаар тодорхой зөвлөгөө өгч ажиллана.

Цаасан болон цахим хэлбэрээр бэлтгэсэн аудитын ажлын баримтууд нь тус компанийн өмч бөгөөд аудиторын тайлан, зөвлөмжийн хамт 10 жил хадгална.

ЗАХИРАЛ



Х.БАЯНБАЙ

Огноо: 2021-03-17

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
6-р хороо, Гео төвийн байр, 407, 408, 409 тоот.
Утас: 976-11-462131, 976-91919758, 976-96969758.
И-мэйл: akpar.audit@gmail.com

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Харилцан тохиролцож байгуулсан гэрээний дагуу "Мон-Ит Булигаар" компанийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг "Аудитын тухай", "Нягтлан бодох бүртгэлийн тухай", "Компанийн тухай" хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн боловруулсан дотоод горимын дагуу гүйцэтгэв.

Байгууллагын талаарх мэдээлэл

1	Байгууллагын нэр	"Мон-Ит Булигаар" ХК
2	Компанийн улсын бүртгэлийн дугаар	9010001072
3	Компанийн регистрийн дугаар	2039184
4	Үйл ажиллагааны чиглэл	Гутлын дээд биений материал үйлдвэрлэх, Арьс шир боловсруулалт, худалдаа, худалдааны зуучлал, гадаад худалдаа
5	Компанийн хаяг байршил	Хан-Уул, 2-р хороо

Материаллаг байдлын түвшин

Материаллаг байдлын түвшинг тэвчиж болох хамгийн багаар буюу нийт орлогын 2.0 хувиар тогтооход 60.2 сая төгрөг байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд Дабль аксиом Аудит ХХК хийж ямар нэг зөвлөмж өгөөгүй байна.

Тасралтгүй үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад нөлөөлөх, эргэлзээ төрүүлэх нөхцөл байдал илрээгүй.

Балансын дараах үйл явдал

Балансын дараа онцгой зүйл илрээгүй.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(Төгрөгөөр)

БАЛАНСЫН ЗҮЙЛ	2019 он	2020 он
I. ХӨРӨНГӨ		
1.1 Эргэлтийн хөрөнгө		
